



127

**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

┌ Хөтөлбөр батлах тухай ┐

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 193 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн төвийн эмч, ажиллагсдын нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллахыг Хүний нөөцийн алба /Л.Болормаа/-д, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхийг Албадын дарга, Поликлиник, Амбулаторийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын ажилтанд даалгасугай.

ДАРГА



Ж.ЭНХЗУЛ

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
20...19 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн
...1/95 дугаар тушаалын хавсралт



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМЧ,
АЖИЛЛАГСДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР**

(2019-2023он)

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1 Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 193 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

1.2 Энэ дагуу “Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч, ажиллагсдын нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийг батлан гаргалаа. Эрүүл мэндийн төвийн ажилтнууд нь халдварт өвчинд өртөх, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчлөх эрсдэлтэй тул ажлын байрны аюулгүй байдлыг хангах, мөн халдварт бус өвчинд өртөх эрсдлээс сэргийлэхийн тулд ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх, зохистой хооллох боломжоор хангах зэргээс анхдагч хүчин зүйлсээс ангижрах боломжоор хангах, түүнчлэн ажлын бүтээмжээр урамшуулал олгох тогтолцоог боловсронгуй болгох, мэргэжил дээшлүүлэх нөхцөл боломжоор хангах, эрүүл аюулгүй ажлын байр бүрдүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах чиглэлд анхаарах шаардлагатай байгаа тул эмч, ажилтнуудын нийгмийн асуудалд цогц байдлаар шийдвэрлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

2.1 Төрийн бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байх

2.2 Ил тод байх

2.3 Салбарын болон нутгийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагаа, дэмжлэгт тулгуурлах

Гурав. Хөтөлбөрийн зорилго

3.1 Эрүүл мэндийн төвийн эмч, ажиллагсдын нийгмийн хамгааллыг сайжруулж, тасралтгүй хөгжих боломжийг нэмэгдүүлэх замаар чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, сэтгэл ханамжийг нь нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго чиглэгдэнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

4.1 Эмч, ажиллагсдын аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаалах

4.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг олгох

4.3 Мөнгөн болон мөнгөн бус урамшууллын шинэ аргыг нэвтрүүлэх

4.4 Эмч, ажиллагсдын нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл ажиллагааг дэмжин, хамтын ажиллагааг өргөжүүлэх

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал

5.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг үнэлэх, шаардлагатай дүрэм, журмыг боловсруулж баталж мөрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах

5.1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ижил загварын ажлын хувцас, ажлын хэрэгслээр тогтмол хугацаанд хангаж шинэчлэх

5.1.3 Албан үүргээ гүйцэтгэж байхдаа заналхийлэл, хүчирхийлэлд өртсөн эрүүл мэндийн ажилтныг хууль, эрх зүйн туслалцаа авахад дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хяналтанд авах, эрүүлжүүлэх ажлыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний алба тогтмол хийх

5.1.4 Эрүүл мэндийн ажилтнууд болон тэдний гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх замаар өвчлөлийг эрт оношилж, өвчлөл хүндрэлээс сэргийлэх, эмч, ажиллагсдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг сайжруулах

5.1.5 Ажиллагсдаа ажлын байранд сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ авах боломжоор хангах

5.1.6 Ажиллагсдын үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг тушаалаар томилон ажиллуулах

5.1.7 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар үе шаттай хийлгэх

5.1.8 Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх, зохистой хооллох боломжоор хангах

5.2 Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, үр чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжоор хангах

5.2.1 Байгууллагын төсөв болон төрийн болон төрийн бус байгууллагын зардлаар эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаадын өндөр хөгжилтэй оронд сургалтанд хамруулах, аялах боломжийг олгох

5.2.2 Төгсөлтийн дараахь төрөлжсөн мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтанд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулах

5.2.3 Ажилд авах, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах журам хэрэгжүүлэх, шинэ ажилтныг чиглүүлэх хөтөлбөрийг боловсруулах, ажлын байранд дадлагажуулах

5.3 Санхүүгийн болон санхүүгийн бус урамшуулал, бодит орлогыг нэмэгдүүлэх

5.3.1 Ажлын бус цагаар үзүүлсэн төлбөртэйтусламж үйлчилгээний орлогын тодорхой хувийг тухайн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эмч, мэргэжилтнүүдэд олгох

5.3.2 Бага хүүтэй цалингийн зээлийг цалин олгогч банкнаас ажиллагсад олгоход дэмжлэг үзүүлэх

5.3.3 Эрүүл мэндийн ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг боловсронгуй болгох, ажлын үр дүнгээр урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, мөнгөн ба мөнгөн бус урамшууллын тогтолцоог нэвтрүүлж, урамшууллыг ажлын гүйцэтгэлийг сайжруулах хөшүүрэг болгох

5.4 Нийгмийн хамгааллын чиглэлийн бүртгэл, судалгааг сайжруулах

5.4.1 Эмч, ажиллагсдын тоо, байршил, хуваарилалт, хүртээмж, сургалтанд хамрагдалт, шилжилт хөдөлгөөний мэдээллийг боловсронгуй болгох

5.4.2 Хөдөлмөрийн чадвар түр алдалт, хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон ажилтны мэдээллийг бүртгэх

5.4.3 Шагнал урамшуулалд хамрагдалтын судалгааг тогтмол шинэчлэх

5.4.4 Эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа

6.1. Хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

7.1 Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгаалал сайжирснаар тэдний сэтгэл ханамж дээшилж, тогтвор суурьшилтай ажиллана

7.2 Чадварлаг хүний нөөц бүрдсэнээр хүнд амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна

7.3 Эмч, ажиллагсдын мэргэжлээс шалтгаалсан осол гэмтэл, хөдөлмөрийн чадвар түр алдалт буурна

131

7.4 Өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлсэн эмнэлгийн мэргэжилтний тоо нэмэгдэнэ

Найм. Хөтөлбөрийн санхүүжилт

8.1 Эрүүл мэндийн төвийн жил бүрийн төсвийн тодорхой хувь

8.2 Үйлдвэрчний эвлэлийн хорооны санхүүжилт

8.3 Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын хөрөнгө оруулалт, хандив тусламж